

## АМЕРИКИЙН УРАН ЗОХИОЛЫГ МОНГОЛ ХЭЛЭЭР ОРЧУУЛСАН ҮЕ ҮЕИЙН ОРЧУУЛАГЧДЫН БҮТЭЭЛ ТУУРВИЛЫН ТОЙМ

А. Өлзийнаран<sup>1</sup>, Н.Оюунзаяа<sup>2</sup>

**Товч утга:** Энэхүү өгүүлэлээрээ Америкийн уран зохиолыг Монголд орчуулсан үе үеийн орчуулагчдын зохиол бүтээлийн тойм гаргав.

**Түлхүүр үг:** америкийн уран зохиол, нэрт төлөөлөгчид, монголын орчуулагчид

Дэлхийн улс орнууд эрт үеэс өөр хоорондоо олон талаар харилцаж, өөрсдийн соёлоо шууд болон дам байдлаар түгээж ирсэн бөгөөд үүний нэг илрэл нь гадаадын уран зохиол, түүнийг орчуулан бусад ард түмний соёлтой танилцаж ирсэн явдал юм.

Монголчууд гадаадын олон орны уран зохиолыг эх хэлнээ хөрвүүлж, утга зохиолын нэг төрөл болтол баяжуулж ирсэн түүхэн уламжлалтай билээ. Орчин үеийн орчуулгын уран зохиолын дотор Америкийн уран зохиол томоохон байр суурийг эзэлдэг.

Монголын орчин үеийн уран зохиолыг үндэслэгч Д.Нацагдорж (1906-1937) нь орчин үеийн Монголын орчуулгыг хөгжүүлэхэд үлэмж их хувь нэмэр оруулсан гавьяатан мөн. Тэрээр 1935 онд Эдгар Аллан По-гийн “Алтан цох” зохиолыг Герман хэлнээс анх орчуулан хэвлүүлж, монголын ард түмнийг Америкийн уран зохиолтой танилцуулсан билээ.

XX зууны монголын орчуулгын хөгжилд дорно дахины суут эрдэмтэн, зохиолч Бямбын Ринчен (1905-1977) үнэлж баршгүй хувь нэмэр оруулсан юм. Б.Ринчен хориод орны далаад зохиолчдын хоёр зуун дөч орчим зохиол бүтээлийг англи, орос, франц, чех, польш, эсперанто зэрэг олон хэлнээс монголоор орчуулсан гэсэн тойм байгаа боловч бүрэн тооцоо хараахан биш. Учир нь түүний орчуулгын бүтээлээс багагүй зүйл үрэгдсэний зэрэгцээ янз бүрийн шалтгаанаар хэвлэгдэж амжаагүй гар бичмэл олдсоор байгаа билээ. Тэрээр Ж.Рид, Ж.Лондон, В.Ветман, Х.Лонгфелло нарын зохиол бүтээлээс орчуулж байсан боловч тодорхой шалтгаанаар тухайн үедээ хэвлэгдээгүй байна. (Р.Гүрбазар, 1996:64 )

Монголчууд Америкийн уран зохиолын олон төрөл жанрыг англи, орос, герман, чех, румын зэрэг хэлнээс хөрвүүлж ирсэн байдаг. Энэхүү сэдвийн хүрээнд америкийн уран зохиолыг монгол хэлнээ орчуулж ирсэн үе үеийн орчуулагчдын зохиол бүтээлийн тойм гаргахыг зорилоо. Үүний тулд, Төв номын сангийн 1921-2005 оны хооронд орчуулагдаж хэвлэгдсэн америкийн

<sup>1</sup> МУИС, ШУС, ХУС-ын ИБАСТ-ийн багш

<sup>2</sup> МУИС, ШУС, ХУС-ын ИБАСТ-ийн багш

уран зохиолын орчуулгын бүтээлүүдийн бүртгэл, номзүйг шүүн, тэдгээрийг төрөл, зохиолч, орчуулагчаар ангилан судалгааны тойм дүгнэлт гаргав.

Америкийн уран зохиолыг монгол хэлээр орчуулсан бүтээлийг дараах байдлаар үечилж, тухайн үеийн орчуулгын уран зохиолын онцлогыг товч дүгнэлээ. Үүнд:

1. 1935-1960
2. 1961-1970
3. 1971-1985
4. 1986-2005

### **1. 1935-1960 оны орчуулгын уран зохиолын онцлог**

1935 онд их зохиолч Д.Нацагдорж Эдгар Аллан По-гийн “Алтан цох” зохиолыг Герман хэлнээс анх орчуулан хэвлүүлж, Америкийн зохиолчдын сонгодог бүтээлүүдийг орчуулах ажлыг эхлүүлсэн юм. Түүнээс хойш Б.Энэбиш, М.Гаадамба, С.Эрдэнээ, Г.Дэлэг, П.Чойжил, Г.Дамдин, Г.Сүхбаатар, Н.Самбуу, Д.Лодойдамба, Д.Бямбаа, Б.Дэмчигдорж, Д.Цэрэндондов, С.Сандагдорж, Ж.Аминдаваа нарын 14 орчуулагч Жек Лондон, Эдгар По, Т.Драйзер, Г.Лонгфелло, А.Мальц, М.Твен, М.Гольд, Г.Фаст зэрэг 15 зохиолчийн 20 сонгодог бүтээлийг герман, орос, англи хэлнээс орчуулсан байна.

Уран зохиолын төрлөөр нь ангилвал:

А) Өгүүллэг:

Эдгар Аллан По “Алтан цох” (Герман хэлнээс Д.Нацагдорж, 1935), Говард Фаст “Пикскилл, Америкийн нэгдсэн улс” (Оросоос орч. М.Гаадамба, 1959), “Тэргэнд зүтгэгч хүн” (Оросоос орч. Н.Самбуу, Д.Лодойдамба, 1953), Жек Лондон “Амьд явахын хүсэл” (орч. Г.Дэлэг, 1944), А.Мальц “Цирк ирлээ” (Англиас орч. Д. Цэрэндондов, 1958), Т.Драйзер “Сэтгэлийн догшин шуурга” (Оросоос орч. Б.Дэмчигдорж, 1957) зэрэг 11 бүтээлүүдийг орчуулагдсан байна.

Б) Шүлэг:

Х.Гардман “Эхийн үг” (орч. С.Эрдэнээ, 1953), Гольд.М “120 сая” (Англиас орч. Д. Бямбаа, 1959), Лонгфелло.Г.У “Ариун нэр” (Англиас орч. Д. Бямбаа, 1958), “Сум дуулал хоёр” (Оросоос орч. М.Гаадамба, 1957), Эдгар Аллан По “Аннабель Ли” (Оросоос орч. С.Сандагдорж, 1954), Ростен.Н “Сан-Франциск-д” (Оросоос орч. Г.Дамдин, 1951) гэсэн 6 шүлэг орчуулагдсан байна.

В) Үлгэр:

Жек Лондон “Орчлонгийн жам” (Орчуулга, 1937), “Кишийн тухай үлгэр” (Оросоос орч. П.Чойжил, 1955) “Тахиа, хулгана, сойр гурав” (Германаас орч. Б.Энэбиш, 1955) гэсэн 3 үлгэр орчуулжээ.

### **2. 1961-1970 оны орчуулгын уран зохиолын онцлог**

Манай орчуулагчид 1950-аад оны дунд үе хүртэл цаг үеийн шаардлагаар зөвхөн орос хэлээр дамжуулан гадаадын зохиолтой танилцаж байсан бол аажмаар олон төрлийн харь хэл эзэмших болсноор бусад орны уран зохиолыг

эх хэлнээс нь шууд орчуулах хандлага давамгайлах болжээ. Энэ үеийн онцлог нь манай сэхээтнүүд америкийн уран зохиолыг ихээхэн сонирхох болсон нь тухайн үед орчуулагдсан бүтээлүүдийн төрөл, тоо, орчуулагчдын тооноос харагдаж байна.Тухайн үеийн орчуулагчдаас Бага Энэбиш, С.Цэрэндэндэв нарын зохиолчид англи хэлнээс түлхүү орчуулж, ялангуяа яруу найргийн бүтээлийг шимтэн орчуулж байсан нь ажиглагдаж байна.

Энэ үеийн гол орчуулагчид болох Бага Энэбиш, Н.Наваан-Юндэн, Б.Бааст, Б.Энэбиш, Г.Биндэрьяа, Бооёо, Х.Нацагдорж, С.Сандагдорж, С.Цэрэндондов, Ц.Шүгэр, Э.Эрдэнэ, Ц.Мөнхжаргал, Г.Лувсанцэрэн, П.Ядамсүрэн, Д.Гомбожав, Ч.Нямдорж, Д.Хишигжаргал, Л.Хуушаан, Х.Лхамдорж, Ц.Балхаажав, Г.Цагаач, Л.Түдэв, Цэнд-очир, Т.Төмөрбат, Ү. Нямдорж, С.Авирмэд, М.Цэдэндорж нарын 26 орчуулагч Арт Бухвальд, О.Генри, Т.Драйзер, Жек Лондон, Ж. Рид, Х.Сэндберг, У.Уитман, Р.Фрост, Л.Хьюз, Э.Хэмингуэй, Э.Дикинсон, Г.Лонгфелло зэрэг 26 зохиолчийн 49 бүтээлийг орос,англи, чех хэлнээс орчуулсан байна.

Уран зохиолын төрлөөр нь ангилвал:

А) Өгүүллэг:

Дуглас.У “Америкчуудын харахад монгол орон” (Орчуулга, 1964), Колдуэлл.Э “Сүүлчийн ой” (Оросоос орч. Г.Биндэрьяа, 1964), Куйна.М “Яап Яап арлын алтан бээлийнүүд”(Англиас орч.Бооёо,1962), Эдгар Аллан По “Хулгайд алдагдсан захидал” (Оросоос орч.Ц.Шүгэр, 1963), “Хүн амины хэрэг” (Оросоос орч.Ц.Шүгэр, 1963), “Ганс Пфролльд учирсан явдал” (Оросоос орч. Ц.Шүгэр,1963),Т. Уолкинс “Баруун зүгийн араншин” (Оросоос орч.Ү.Нямдорж, 1962), Бухвальд.А “Хэний ч санаанд ороогүй юм даа” (Оросоос орч.С.Цэрэндэндэв, 1966), Генри.О “Сүүлчийн навч” (Англиас орч. Л.Хуушаан, 1966), Азимов.А “Аялгуут хонх” (орч.Р.Доржсүрэн, 1970) зэрэг 6 өгүүллэг хөрвүүлэгдсэн байна.

Б) Шүлэг

Робинзон.Э.А “Ричард Кори” (Англиас орч.Бага Энэбиш, 1963), Сегал.Э “Шувуу байсан бол”,“Гүүр” (Англиас орч.Бага Энэбиш, 1963), Сэндберг.Э “Алхаад өнгөр” (Англиас орч.Бага Энэбиш, 1963), Уитман.У “Америкийг дуулахыг сонсном”, “Бүсгүй намайг хүлээж байгаа” (Орчуулга,1962), “Өвсний навч” (Оросоос орч. Д.Гомбожав, 1964), Р.Фрост “Билчээрт”, “Навчис” (Англиас орч.Бага Энэбиш, 1963), “Алсын тэртээгээс”, “Бадарчинд биширсэн нь”, “Эрэлчин”, “Навчын ертөнц” (Оросоос орч.Г.Лувсанцэрэн,1963), “Хусан шугуй” шүлгүүд (Оросоос орч.Г.Лувсанцэрэн, 1966), Л.Хьюз “Саад хашлага хилийн харуулыг ч хайхрахгүй” (Англиас орч.С.Цэрэндэндэв, 1962), “Ажилгүй хүн”, “Хөрөнгөтний бодол”, “Дарлал”, “Хав харанхуй шөнө”, “Өнөөдөр” (Англиас орч. Бага Энэбиш, 1963),“Африк” (Англиас орч. С.Цэрэндэндэв, 1963), Жон Рид “Бид бол хувьсгалчид”, “Хүү минь үүнийг ойлгоорой”, “Дайн үргэлжилсээр байна” дуунууд (Оросоос орч. Л.Хуушаан, 1967), Сэндберг.Х “Турван үг” (Оросоос орч.М.Цэдэндорж, 1968), “Тоорой хайлаас хоёр” (Оросоос орч.С.Авирмэд, 1969), Уйтмен.У “Буурал нь баярлалаа”, “Өдөр өнгөрөхийн хэрд

сонсоод би” (Оросоос орч. М.Цэдэндорж, 1969), ”Гайхамшиг” (Оросоос орч. М.Цэдэндорж, 1968), Жо Хилл “Бид дуулна” (орч.Ш.Цогт, 1970) зэрэг 20 орчим шүлэг орчуулагдсан байна.

В) Тууж

Эрнест Хэмингуэй “Өвгөн тэнгис хоёр” (Оросоос орч.С.Сандагдорж, 1961), Игер.Э “Шидэт долоо хоног” (Англиас орч. Г.Цагаач, Л.Түдэв, 1968) гэсэн 2 тууж орчуулагдсан байна.

Г) Роман

Бичер Стоу.Г “Том авгын овоохой” (Оросоос орч. Н.Наваан-Юндэн), Драйзер.Т “Америкийн эмгэнэлт явдал” (Оросоос орч. Б.Энэбиш, Г.Амар, 1960), “Америкийн эмгэнэлт явдал” 2-р дэвтэр (Оросоос орч. Б.Энэбиш, Г.Амар, 1968), “Женни Герхард” (Оросоос орч.Х.Лхамдорж, Ц.Балхаажав, 1966), “Амьдралын баатар” (Англиас орч.Л.Дашням, 1970), Жек Лондон “Мартин Иден” (Оросоос орч.Г.Төмөрбат, Ү.Нямдорж, 1969), Твен.М “Гекельберри Финнад тохиолдсон адал явдал” (Оросоос орч. Г.Төмөрбат, 1965), Ж.Купер “Сүүлчийн Могикан” (Оросоос орч. Г.Амар, 1970), Эрнест Хэмингуэй “Зэр зэвсэг минь баяртай” (Оросоос орч.М.Цэдэндорж, 1970) зэрэг 10 орчим роман орчуулагдаж уншигчдын хүртээл болжээ.

### 3. 1971-1985 оны орчуулгын уран зохиолын онцлог

Энэ үеийн орчуулагчид Америкийн уран зохиолын төрлүүдээс өгүүллэгийг голчлон орчуулж байсан бөгөөд “Бродвэйн шөнө” хэмээх 18 өгүүллэгийн эмхэтгэлийг олон орчуулагч хамтран гаргасан байна. Мөн англи хэлнээс орчуулагчдын тоо олширсон нь ажиглагдаж байна. Тухайлбал, Ч.Алагсай, Л.Дашням, Н.Доржготов,Н.Цэвэгмид, Чимэддорж, Ц.Гомбосүрэн. Б.Цэрэндаш, Д.Алтанхуяг нарыг дурдаж болох юм. Орчуулагч Д.Бямбаа шүлэглэсэн бүтээлийг орчуулахад нилээд гаршиж байсан төдийгүй “Хэрэв бүх тэнгисийг нэг тэнгис болговол” хүүхдийн шүлгийн номыг дангаараа орчуулж байжээ.

Р.Доржсүрэн, Ч.Алагсай, Б.Пүрэвсүрэн, Л.Дашням, Ш.Цогт, Г.Амар, Р.Санжаасүрэн, Ч.Оюун, Д.Лодойдамба, Ж.Лхагва, Б.Ламжав, М.Цэдэндорж, Н.Доржготов, Л.Хуушаан, Чимэддорж, Н.Цэвэгмид, Ц.Сумъяа, Ц.Цэрэн, Д.Нацагдорж, Б.Энэбиш, А.Шархүү, Ц.Гомбосүрэн, Д.Лхамжав, Д.Цэцэгмаа, Д.Алтанхуяг, Б.Цэрэндаш, Г.Аким, Р.Юра, С.Хаш-эрдэнэ, С.Пүрэв, С.Одбал, С.Чулуунбат, Б.Батбаяр, Д.Бямбаа, Б.Жамсранжав, Ц.Ганзориг, М.Зээхүү нарын 38 орчуулагч Америкийн 35 зохиолчийн 66 бүтээлийг англи, орос хэлнээс эх хэлнээ хөрвүүлжээ.

Уран зохиолын төрлөөр нь ангилвал:

А) Өгүүллэг

Андерсон.Ш “Багш” (орч.Ш.Сумъяа, 1974), “Бродвэйн шөнө” Америк өгүүллэгийн эмхэтгэл (Ред. Л.Дашням, 1974), Гоүлд.М “Нөгөө гайхал ухуулагч” (орч. Д.Нацагдорж,1974), Драйзер.Т “Харанхуйгаар”, “Цастайд”, “Шуурганаар” (орч. Д.Лхамжав, 1974), Колдүвелл.Э “Охин минь”, “Кристи Такер амь эрсэдсэн

нь” (Оросоос орч.Н.Доржготов, 1974), Күйн.М “Хавьтамгүй эр”, “Хүний адаг хөрөнгийн эзэн” (Оросоос орч.Д.Нацагдорж, 1974), Мальц.А “Замд тааралдсан хүн” ( орч. Д.Цэцэгмаа, 1974), “Үд дундын балар ой” (орч. Д.Алтанхуяг, 1974), Ж.Рид “Америк мак”, “Бродвэйн шөнө” (орч. Д.Нацагдорж, 1974), Сандерсон.А “Усны хүмүүс” (орч. Г.Аким, 1974), Сароян.В “Хоньчин охин” (орч. Н.Доржготов, 1974), Эрнест Хэмингуэй “Индианын гацаа” (орч.Н.Доржготов, 1974), “Испаний төлөө нөгцсөн Америкчуудад” (орч.Л.Алтанхуяг, 1974), Эрнест Хэмингуэй “Климанжарогийн цас” (Англиас орч.Л.Алтанхуяг, 1976), Хенри.О “Цэнхэр хувцастан ба мөргөлийн дуулал” (орч. Л.Алтанхуяг, 1974), Хьюз.Л “Түшиглэх юм чинь” (орч. Д.Нацагдорж,1974), Бредбери.Р “Тэнгэрт гарсан хүн” (орч. М.Зээхүү, 1976), Бредберри.Р “П-гэж пуужин” (орч.Н.Цэвэгмэд, 1977), “Сансрын нисэгч” (орч. С.Чулуунбат 1978), Бухвальд.А “Пентагоны шинэ жилийн үдэш” (орч.С.Хаш-Эрдэнэ, 1978), Драйзер.Т “Мундаг эр” (орч.Ц.Гомбосүрэн, 1973), Райт.Р “Зарц” (орч.С.Пүрэв, 1978), Раскатов.М “Цатгалан муур өлсгөлөн хүмүүсийн дууль” (орч.С.Одбал, 1978), Эрнест Хэмингуэй “Гүүрийн дэргэд суугаа өвгөн” (орч.Д.Алтанхуяг, 1979), Квентин.П “Жо ахыг хэн буудав” (орч.Ц.Цэрэн, 1980), Генри.О “Хайр сэтгэл” (орч.Н.Доржготов, 1984), Лингстон Хьюз “Би негр хүн” (орч. Б.Жамсранжав, 1981), Марк Твен “Тахал” (орч. Ц.Ганзориг, 1981), Шервуд Андерсон “Этгээд хүний тухай ном” (орч.Н.Доржготов, 1984) зэрэг 37 өгүүллэг орчуулсан байна.

#### Б) Шүлэг

Өргөнгөө Онон “Монгол гэр” (Монголоор бичсэн шүлэг, 1971), “Хэрэв бүх тэнгисийг нэг тэнгис болговол” Хүүхдийн шүлгүүд (орч. Д.Бямбаа, 1978), Лингстон Хьюз “Америк минь бос” (орч. Б.Жамсранжав, 1981), Огден Нэш “Улс төрийн хэнээтэн” (орч. Д.Бямбаа, 1983) зэрэг шүлгүүдийг дурдаж болно.

#### В) Роман

Драйзер.Т “Амьдралын баатар” (Англиас орч. Б.Пүрэвсүрэн, 1971), “Америкийн эмгэнэлт явдал” (орч. Б.Энэбиш, А.Шархүү, 1974), “Санхүүч” (Англиас орч. Ц.Гомбосүрэн, 1973), Эрнест Хэмингуэй “Африкийн ногоон толгод” (орч. Д.Алтанхуяг, Н.Цэвэгмид, 1979) зэрэг 4 романыг орчуулсан байна.

### 4. 1986-2005 оны орчуулгын уран зохиолын онцлог

Нийгмийн хувьсалыг даган энэ цаг үеийн орчуулгын бүтээлүүд нь сонголтын хувьд чөлөөтэй болж, орчуулагчдын тоо олширсон бөгөөд бүтээлийг эх хэлнээс нь орчуулах явдал зонхилох болсон ч орчуулгын чанарт тавигдах хяналт үгүй болсонтой уялдан олон тооны доголдлууд ажиглагдах болсон байна. Энэ үед Ц.Цэрэн, Д.Алтанхуяг, Ц.Барадий, Д.Дашмөнх, Д.Лхамжав, П.Чойжил, Б.Пүүшил, Б.Чимэдбат, Г.Аюурзана, Н.Энхбаяр нарын зэрэг 40 орчим орчуулагч Америкийн 53 зохиолчийн 280 гаран бүтээл, үүний дотор 232 өгүүллэг, 21 роман, 6 тууж болон шүлэг найруулал орчуулсан байна.

Уран зохиолын төрлөөр нь ангилвал:

#### А) Өгүүллэг

Энэ үеийн орчуулгын зохиолын дийлэнх хувийг өгүүллэгийн төрөл зүйл эзэлж байна. Үүнд:

- Бухвальд.А “Америк орон ба Америкчууд” (Англиас орч. Ц.Цэрэн нар, 1985)Тус номонд Арт Бухвальдын “Ааваа юу болсон бэ”, “Аяд нийцэхгүй байна”, “Бичиг үсэгт тайлагдаагүй хүний коллеж”, “Муухай юманд зориулсан цэвэр бөмбөг” гэх мэт шилдэг хошин 136 өгүүллэг;

- Генри.О-ийн “Алгаараа соронздогч Жефф Питерс” (Оросоос орч. Б.Чимэдбат, 2002), “Балчрууд ширэнгэнд” (Англиас орч. С.Авирмэд,2002), “Бидний сонгосон зам” (Англиас орч. С.Авирмэд, 2002), “Биедээ татахдаа гарамгай Джефф Питерс” (Англиас орч. С.Авирмэд, 2002) зэрэг 47 өгүүллэг

- Жек Лондоны “Алс тэртээх хязгаарт”, “Амьдралын жам”, “Жис-Укын түүх” зэрэг 13 өгүүллэгийг орос хэлнээс орчуулагч Б.Чимэдбат 2001 онд орчуулж хэвлүүлсэн бол “Амьд явахын хүслэн” (орч. Ж.Дамдинсүрэн, 1998), “Аян замын арга ухаан” (орч. Г.Амар, 2002), “Хүний амь” (орч. Ш.Очирбат, 1997) гэх мэт 6 өгүүллэг монгол хэлнээ хөрвүүлэгдэн бидний гар дээр иржээ.

- Бэрретт.М “Шулмын эзгүй шөнө” (орч. Д.Алтанхуяг, 1992), Айзек Азимов “Ялан дийлэгч машин” (орч. З.Туул, 1989), Шервуд Андерсон “Хувцасны шүүгээ” (Оросоос орч. Д.Бадарч, 1996), Рэй Дуглас Брэдбери “Хог” (орч. Д.Цэрэн, 1989), Эрл Стенли Гарднер “Өмгөөлөгч Перри Мейсон (орч. Д.Алтанхуяг ,1992), “Ууртай гэрч” (орч. Д.Мөнхбаяр, 1992), Кларк Говард. “Амь дэнссэн хэрэг” (Англиас орч. Б.Байгаль, 1992), “Мафи” (Англиас орч. Ц.Барадий,1992), Зингер.И.Б “Золиос” (орч. Г.Аюурзана, 2000), Стивн Кинг “Буг” (орч. Д.Дашмөнх ,1998), Эллери Куин “Жолооны ард хэн байв” (орч. Д.Дашмөнх ,1998), Ричард Льюис “Бодлоо илчилсэн нь” (орч. Д.Бямбацогт, 1993), Мактарроу.Ф “Дуугүй байх бол алт” (орч. Д.Дашмөнх, 1998), Росс Макдональд “Кадиллак машинтай хүн” (орч. П.Чойжил, 1997),Эдгар По “Морт гудамжинд гарсан хүн амины хэрэг (орч. П.Чойжил, 1993), Ричард Скот Пратер “Хилэнцийн гудамж” (орч. П.Чойжил, 1997),“Эргэн тойрон луйвар” (орч. Д.Мөнхбаяр, 1996) зэрэг 232 өгүүллэг тус цаг үед орчуулагдсан байна.

#### Б) Шүлэг

Аллен Гинсберг “Аглаг зэлүүд хадат ууланд” гурван мөрт шүлгүүд (орч. Д.Одонхорлоо, 2004), “Битгий өтлөөрэй” (орч. Д.Одонхорлоо, 2004), “Бурклины лут ухаантан” (орч. Д.Одонхорлоо, 2004), “Дөрвөн давхарт шөнөжин захидал бичэхүй дор үүр хаяарлаа” (орч. Д.Одонхорлоо, 2004), “Хэн Америкийг удирдаж байна вэ” (орч. Д.Одонхорлоо, 2004) зэрэг цөөн тооны шүлгүүд орчуулагджээ.

#### В) Тууж

Ричард Бах “Жонатан Ливингстон хэмээх цахлай” үлгэр тууж (орч. Н.Энхбаяр, 2005), Дональд Вестлейк “Цагдаа хулгайчид” (орч. Ц.Барадий, 1992), Чарльз Вильямс “Эмэгтэй хүний турьхан гар” (орч. Ц.Барадий, Д.Мөнхбаяр, 1992), Жек Лондон “Догшин араатан” (Оросоос орч. Ж.Дамдинсүрэн, 1994), Уильям Фолкнер “Баавгай” (орч. Г.Аюурзана, 2000),

Раймонд Чандлер “Невадын хорт хий” (орч. Ц.Барадий,1992) зэрэг 6 тууж орчуулагдсан байна.

#### Г) Роман

Болдхид.В “Эзний хэргэмд дэвших ёслол” (орч. С.Дашдондов, 1995), Жон Болл “Каролины бүгчим шөнө” (орч. Д.Бямбацогт, 1993), Пол Берховен “Төрөлхийн араншин” (орч. С. Отгонтөгс, 1998), Дональд Вестлейк “Хараал идсэн маргад эрдэнэ” (орч. Д.Бямбацогт, 1993), Чарльз Вильямс “Ням гарагийн тарчлаант шөнө” (орч. А.Эрдэнэтөгс, 1992), Эрл Стенли Гарднер “Өмгөөлөгч Перри Мейсон (орч. Д.Алтанхуяг, 1991), Дэвид Моррел “Рэнбо-1” (орч. Д.Бямбацог, 1994), Рекс Стаут “Одоо устгачих, хөлсийг нь дараа төлнө” (орч. С.Дашдооров 2004), Дональд Уэйстлейк “Цагдаа хулгайч хоёр” (орч. Ш.Янсанжав, 1994), Дешил Хеммит “Их гарын дээрэмчид” (орч. Н.Энхболд, 1992), Питерс Чейни “Хэрэг дууссанд тооц” (орч. Ц.Барадий, 1995), Сидни Шелдон “Багийг нь хуу татагтун” (орч. П.Чойжил, 2005), “Сурвалжлагч Дейна Эванс” (орч. С.Дашдондов, 2004), Виктор Эфтому “Тэнгэр” романы хэсэг (орч. Б.Чимэдбат, 1993) зэрэг 21 роман орчуулагдсан байна.

#### Дүгнэлт

Судалгаанаас нэгтгэн дүгнэвэл, 1921-2005 оны хооронд Америкийн уран зохиолыг 120 орчим монгол орчуулагчид 130 гаруй зохиолчийн 380 гаруй бүтээлийг орос, англи, герман, чех, румын хэлнээс орчуулжээ. Үүний дотор 50 гаруй зохиолчийн 200 гаруй өгүүллэг, 14 яруу найрагчийн 90 гаруй шүлэг, 60 гаруй роман, 10 гаруй тууж, хэд хэдэн дууль, үлгэр, найраглал, туурийг орчуулсан байна.

Судалгааны явцад хэд хэдэн зүйл ажиглагдлаа. Үүнд:

- 1935-1960 онд их зохиолч Д.Нацагдорж 1935 онд Эдгар Аллан Погийн “Алтан цох” зохиолыг Герман хэлнээс анх орчуулан хэвлүүлж, монголын ард түмнийг Америкийн уран зохиолтой танилцуулж, орчуулах ажлыг эхлүүлсэн юм. Тухайн үеийн онцлог нь орчуулагчдын тоо харьцангуй цөөн байсан бөгөөд ихэнх зохиол бүтээлүүдийг орос хэлнээс орчуулж байжээ. Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан зарим орчуулгын бүтээлүүд тухайн үедээ хэвлэгдээгүй байна.

- 1961-1970 онд орчуулагчдын тоо олширч, үүнийг дагаад орчуулгын уран зохиолын төрөл баяжсан байна. Мөн Америкийн уран зохиолыг орос хэл төдийгүй англи хэлнээс шууд орчуулах хандлага давамгайлах болсон байна.

- 1971-1985 он бол орчуулгын хөгжилд нилээд олол амжилт бүхий үе юм. Энэ үед манай нэрт орчуулагчид америкийн сонгодог бүтээлүүдийг олноор нь орчуулж, хамтран эмхтгэл гаргаж байлаа. Үүний нэг жишээ нь “Бродвэйн шөнө” өгүүллэгийн эмхэтгэлийг нэрлэж болох юм.

- 1986-2005 он бол шинэ үеийн орчуулагчид нилээд төрөн гарсан бөгөөд бүтээлийн тооны хувьд өмнөх үеүдтэй харьцуулахад харьцангуй их юм. Хэдий тийм боловч орчуулгын бүтээлийн төрөл зүйлийн хувьд нилээд

хумигдсан тал ажиглагдаж байна. Мөн орчуулгын чанарт тавигдах хяналт үгүй болсонтой уялдан орчуулгын алдаа дутагдал гарах болж, түүнийг засч сайжруулах асуудал орхигдох болсон байна.

Энэ бүгдээс дүгнэн үзвэл, бид орчуулгын сэтгэлгээ, уламжлалаа хадгалж, цаашид улам хөгжүүлэх асуудал бид бүгдийн өмнө нь зүй ёсоор тавигдаж байна.

### Номзүй

1. 1921-1955 онд монгол хэлэнд орчуулсан гадаад уран зохиолын бүртгэл, Улсын хэвлэлийн газар, УБ, 1957: 8
2. Гадаадын уран зохиолыг монгол хэлээр орчуулсан нь (1956-1960) УБ, 1963:57
3. БНМАУ-д 1961-1964 онд хэвлэгдсэн гадаадын уран зохиолын бүртгэл, УБ, 1966: 61-64
4. Г. Пүрэвдорж, БНМАУ-д хэвлэгдсэн гадаадын уран зохиол, утга зохиолын судлал (1965-1969) , УБ, 1972: 110-112
5. Ш. Базар, БНМАУ-д хэвлэгдсэн гадаадын уран зохиолын судлалын судлалын номзүй (1970-1972) , УБ, 1974: 22-24
6. Ш. Базар, БНМАУ-д хэвлэгдсэн гадаадын уран зохиол, утга зохиолын судлалын номзүй (1973-1974) , УБ, 1976: 25-28
7. Ш. Базар, БНМАУ-д хэвлэгдсэн гадаадын уран зохиолын номзүй (1975-1976) , УБ, 1978: 10
8. БНМАУ-д хэвлэгдсэн гадаадын уран зохиолын номзүй (1977-1980) , УБ, 1983: 12-14
9. БНМАУ-д хэвлэгдсэн гадаадын уран зохиолын номзүй (1981-1984) , УБ, 1987: 22
10. Yu. Munkh-Amgalan, “A survey of American Literature in Mongolia and its place in Mongolian Education” Mongolian studies: Journal of The Mongolia Society. Volume XXVI (2003/4)
11. Р. Гүрбазар, “Орчуулгын онол, дадлагын үндэс, УБ. 1996